

ҮНЭЛГЭЭЧИНД ТЭРГҮҮЛЭХ ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Үнэлгээний мэргэжлийн байгууллага /цаашид институт гэх/-ын гишүүн үнэлгээчинд институтийн дүрмийн 4.5-д заасныг үндэслэн мэргэшлийн зэрэг олгохтой холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Тэргүүлэх үнэлгээчний зэргийг энэ журмын 3.2-д заасан шалгуур хангасан тусгай зөвшөөрөлтэй үнэлгээчинд сонгон шалгаруулалтын журмаар олгоно.
- 1.3. Тэргүүлэх үнэлгээчний зэргийг дараахь чиглэлээр төрөлжүүлэн олгож болно.
~~1.3.1 Хөдлөх хөрөнгийн тэргүүлэх үнэлгээчин,~~
(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар хасав)
1.3.2 Үл хөдлөх хөрөнгийн тэргүүлэх үнэлгээчин,
1.3.3 Тэргүүлэх үнэлгээчин гэх мэт.
- 1.4. Энэ журмын 1.3-д заасан зэрэг олгох шалгалтад хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийг анх удаа авч байгаа үнэлгээчин орохгүй.

Хоёр. Тэргүүлэх зэрэг олгох шалгалтын комисс

- 2.1 Институт нь хөрөнгийн үнэлгээчинд “Тэргүүлэх зэрэг олгох шалгалтын комисс /цаашид ТЗОШК гэх/ –ыг Тэргүүлэх зэргийн үнэлгээчдээс бүрдсэн 5-7 гишүүнтэйгээр байгуулж, гүйцэтгэх захирлын тушаалаар томилно.
(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар өөрчлөв)
- 2.2 ТЗОШК-ын даргыг, гүйцэтгэх захирал томилох ба комиссын гишүүдийн хурлаар орлогч дарга, нарийн бичгийн даргыг сонгоно.
- 2.3 ТЗОШК нь журмын 1.3-д заасан чиглэл тус бүрээр шалгаруулалтын зохион байгуулах дэд комисст хуваагдаж болох бөгөөд дэд комиссын ахлагчийг ТЗОШК-ын дарга сонгоно.
(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар хасав)
- 2.4 ТЗОШК нь үнэлгээчинд мэргэшлийн зэрэг дэв олгох шалгаруулалтыг шударга, хараат бус, бие даасан байдлаар зохион байгуулах үүрэгтэй.
- 2.5 Дэд комиссын хурал болон шалгаруулалтын үйл ажиллагаа нь гишүүдийн хүрэлцэхүйц ирцтэйгээр явагдвал зохино.
(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар хасав)
- 2.6 ТЗОШК-ын гишүүдийн нэгдсэн хурал гишүүдийн 2/3 нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр байна.
- 2.7 Хүндэтгэн үзэх шалтгаанаар дэд комиссын аль нэгэн гишүүн шалгаруулалтыг зохион байгуулах үйл ажиллагаанд оролцож чадахгүй болсон тохиолдолд ТЗОШК-ын дарга гарсан гишүүний оронд шинэ гишүүн томилон ажиллуулна.
(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар хасав)
- 2.8 ТЗОШК-ын гишүүдийн аль нэг нь шалгаруулалтын үйл ажиллагаанд оролцож чадахааргүй бол ТЗОШК-ын даргын саналыг үндэслэн институтээс бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж болно.
(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар өөрчлөв)

Гурав. Тэргүүлэх үнэлгээчний сонгон шалгаруулалтад орох үнэлгээчинд тавигдах шаардлага

3.1 Тэргүүлэх үнэлгээчний сонгон шалгаруулалтад орохыг хүссэн Тусгай зөвшөөрөл бүхий үнэлгээчин нь дараахь бичиг баримтыг бүрдүүлж институтад ирүүлнэ. Үүнд:

3.1.1 Тэргүүлэх үнэлгээчний сонгон шалгаруулалтад орохыг хүссэн өргөдөл
(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар өөрчлөв)

3.1.2 Мэргэшсэн үнэлгээчний тусгай зөвшөөрлийн хуулбар
(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар өөрчлөв)

3.1.3 Хөрөнгийн үнэлгээний ажилд хэрхэн оролцож, гүйцэтгэсэн тухай, дадлага туршлага, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн тухай холбогдох байгууллагаас авсан тодорхойлолт

(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар өөрчлөв)

3.1.4 Шалгаруулалтын төлбөр төлсөн баримт

3.1.5 Ур чадвар, дадлага туршлагатай гэдгээ нотлосон 3-5 ш үнэлгээний тайланг хийсэн үнэлгээний тайлангийн жагсаалтын хамт

(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар өөрчлөв)

3.2 Тэргүүлэх үнэлгээчний зэрэг дэв олгоход дараахь шаардлага тавигдана. Үүнд:

3.2.1 Хөрөнгийн үнэлгээчний тусгай зөвшөөрлийг тасралтгүй сунгуулж, үнэлгээний чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан байх;

(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар өөрчлөв)

3.2.2 Хөрөнгийн үнэлгээний гэрээт ажилд ахлан оролцож, үнэлгээний ажлын хэсэг болон багийг удирдан ажиллаж ирсэн туршлагатай, үнэлгээчдийг дадлагажуулж, туршлагажуулахад оролцдог байх, хөрөнгийн үнэлгээний тайланд мэргэжлийн дүгнэлт гаргах, 3-аас доошгүй институтын магадлан итгэмжлэх (эксперт) ажилд оролцсон байх;

(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар өөрчлөв)

3.2.3 Хөрөнгийн үнэлгээний чиглэлээр зохион байгуулсан сургалтад хичээл заах, заавар журам, аргачлал боловсруулах, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх, ном сурах бичиг зохиох, сургалтын материал боловсруулахад манлайлан оролцдог байх;

(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар өөрчлөв)

3.2.4 Үнэлгээчний баримтлах зарчим, ёс зүйн дүрэм, үнэлгээ хийж болохгүй нөхцлүүдийг даган мөрдөж, мэргэжил арга зүйн болоод ёс зүйн алдаа гаргаагүй байх;

3.2.5 Институтэд гишүүнээр элсэж, гишүүнийхээ үүргийг бүрэн биелүүлж, тасралтгүй боловсролын заавал хамрагдах, сургалт, семинарт бүрэн оролцсон байх, гишүүний татвараа цаг хугацаандаа төлдөг байх, мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх.

(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар өөрчлөв)

Дөрөв. Тэргүүлэх зэрэг олгох сонгон шалгаруулалт

4.1 Тусгай зөвшөөрөлтэй үнэлгээчин нь энэ журмын 3.2-т заасан шаардлагыг хангаж байгаа бол тэргүүлэх зэрэг олгох ярилцлагад орох эрхтэй.

4.2 Тэргүүлэх зэрэг олгох шалгаруулалтын шалгалт нь ярилцлага хэлбэртэй байна.

4.3 Ярилцлага хийж үнэлгээ өгөх үед ТЗОШК-ын ирц 2/3-аас доошгүй байх ба ярилцлагыг комиссын гишүүд **Хангалттай** ба **Хангалтгүй** гэсэн хувилбараар үнэлнэ. Хангалттай гэсэн оноо өгсөн гишүүдийн тоо ярилцлагад оролцож үнэлгээ өгсөн ТЗОШК-ын гишүүдийн 80 ба түүнээс дээш хувь байвал ярилцлагад тэнцсэн гэж тооцно.

4.4 ТЗОШК нь ярилцлагад тэнцсэн үнэлгээчдэд тэргүүлэх зэрэг олгуулах саналаа жагсаалтаар гаргаж материалыг институтын Удирдах Зөвлөлд ирүүлнэ.

~~4.5 Удирдах зөвлөл нь ММҮИ-ийн дүрмийн 8,17,2-т заасны дагуу дүгнэлт гаргаж, Тэргүүлэх зэрэг олгох үнэлгээчдийн нэрсийн жагсаалтыг Сангийн яаманд өргөн мэдүүлнэ.~~
(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар хасав)

4.6 Институт нь шалгалтын материалыг архивт хадгална.

4.7 Шалгалтын дүнтэй холбоотой маргаан гарвал, санал гомдлыг бичгээр авч, институтаас томилогдсон хөндлөнгийн комисс дахин шийдвэрлэж болно.

(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар өөрчлөв)

Тав. Тэргүүлэх зэрэгтэй үнэлгээчний үнэмлэх ба түүнийг баталгаажуулах

5.1 Тэргүүлэх үнэлгээчний зэрэг олгосон үнэмлэхний загварыг институт баталж, шалгаруулалтад тэнцсэн үнэлгээчдэд олгох үнэмлэхийг институтийн тэргүүн гарын үсэг зурж баталгаажуулна.

5.2 Тэргүүлэх үнэлгээчний зэрэг нь хөрөнгийн үнэлгээчний тусгай зөвшөөрлийн хамтаар хүчинтэй үйлчилнэ.

~~5.3 Үнэлгээчин хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн болон бизнесийн тэргүүлэх үнэлгээчний зэргийн хоёр ба түүнээс олон шалгаруулалтад тэнцсэн тохиолдолд тус бүрд нь болон хамтатгасан үнэмлэх олгож болно.~~

(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар хасав)

5.4 Тэргүүлэх зэрэг авсан үнэлгээчин ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй бол тусгай зөвшөөрөл сунгах дараагийн шатны шалгалтаас чөлөөлөгдөж болно.

(Удирдах Зөвлөлийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлаар хасав)

5.5 Тэргүүлэх үнэлгээчний зэрэг бүхий тусгай зөвшөөрөлтэй үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээний тайланд магадлагаа хийж дүгнэлт гаргах болон экспертээр томилогдон ажиллах эрх эдэлнэ.

Зургаа. Хариуцлага

6.1 Тэргүүлэх зэрэгтэй үнэлгээчин нь Үнэлгээчний Ёс зүйн дүрмийг удаа дараа зөрчин 3-аас доошгүй удаа 8.1-д заасан арга хэмжээ авагдсан тохиолдолд Тэргүүлэх зэргийг хураана.

(Тэргүүлэх зэргийн үнэлгээчний үнэмлэхний загварыг хавсаргав.)

Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институт